



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Аюушийн АРИУНЗАЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-01, Факс: 32-70-16
E-mail: ariunzaya.a@parliament.mn
http://www.parliament.mn

2026.06.04 № ЧИХ-03/6436
танай _____-ны № _____-г

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хуулийн төсөл, холбогдох тайланг хавсаргав.
Хавсралт...??.хуудастай

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



А.АРИУНЗАЯА

Д.БАТЛУТ

Л.МӨНХБАЯСГАЛАН

М.НАРАНТУЯА-НАРА

Б.ТҮВШИН

Г.ТЭМҮҮЛЭН

А.УНДРАА

С.ЭРДЭНЭБАТ

Л.ЭНХНАСАН

00000087



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Аюушийн АРИУНЗАЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-27-01, Факс: 32-70-16
E-mail: ariunzaya.a@parliament.mn
http://www.parliament.mn

2026.05.27 № УИХ-03/6074
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд “Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль, тогтоомжийн тухай хуулийн дагуу 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн УИХ-03/4023 албан тоотоор хуулийн төсөлд санал авахаар Засгийн газарт хүргүүлсэн боловч, хуульд заасан хугацаанд санал ирээгүй тул Хууль, тогтоомжийн тухай хуулийн 21.12-т заасны дагуу Засгийн газраас тусгайлан өгөх саналгүй гэж үзлээ.

Иймд хуулийн төсөл, үзэл баримтлал, товч болон дэлгэрэнгүй танилцуулга, холбогдох тайланг хавсаргав.

Хууль, тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт...~~46~~...хуудастай

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



А.АРИУНЗАЯА

12067085

201



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД НЯМ-ОСОРЫН
УЧРАЛ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Аюушийн АРИУНЗАЯА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
http://www.parliament.mn

2026 04 15 № 311X-03/4023

танай _____-ны № _____-т

Г Хуулийн төсөлд санал авах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасны дагуу Засгийн газрын санал, дүгнэлтийг авахаар хүргүүлж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэгт заасны дагуу саналаа ирүүлнэ үү.

Хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга, холбогдох тайланг хавсаргав.


Хавсралт...³⁹...хуудастай.

Хүндэтгэсэн,


МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ГИШҮҮН



А.АРИУНЗАЯА



99000071



2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн өөрийн санаачлах хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, батална” гэж заасны дагуу энэхүү үзэл баримтлалыг боловсрууллаа.

Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл болон практик шаардлага байна.

1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “иргэн хөдөлмөрлөх, хөдөлмөрийн шударга нөхцөлөөр хангагдах” эрхийг, Арван зургаадугаар зүйлийн 5 дахь хэсэгт “өндөр нас, хөдөлмөрийн чадвараа алдах зэрэг тохиолдолд нийгмийн хамгаалал, туслалцаа авах” эрхийг тус тус баталгаажуулсан.

Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.1-д “Ахмад настан, тэтгэвэр авагч хөдөлмөр эрхэлж болно”, Ахмад настны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.9-д “Ахмад настан хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллах бол Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.6-д заасны дагуу тэтгэврийн даатгалд даатгуулахгүй байж болно” гэж тус тус зохицуулсан нь тэтгэвэр авагчийн хөдөлмөр эрхлэх эрхийг хүлээн зөвшөөрч, нийгмийн даатгалын харилцаанд оролцох нөхцөлийг тодорхойлсон байна. Гэвч Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн зохицуулалтыг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан насны шалгууртай уялдуулан хэрэглэж байгаа нь тэтгэвэр тогтоолгосон иргэн бүрд бус, зөвхөн тодорхой насны нөхцөлийг хангасан тэтгэвэр авагчид тэтгэврийн даатгалд хамрагдах эсэхийг сонгох боломж олгож, бусад тэтгэвэр авагчийг уг эрхээс хасаж байгаа нь хөдөлмөр эрхлэх эрхийг бодитоор хязгаарлах, хөдөлмөрийн үр шимийг бууруулах, нийгмийн хамгааллын бодлогын зорилготой зөрчилдөх, ялгавартай нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд Үндсэн хуулиар баталгаажсан эрхийг бодитой хэрэгжүүлэх, хууль хоорондын уялдааг хангах, хуулийн зөрчлийг арилгах хууль зүйн үндэслэлтэй юм.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн зохицуулалт нь тэтгэвэр авагчийн нийгмийн даатгалд хамрагдах эсэх асуудлыг

тодорхойлох зорилготой боловч уг зохицуулалт нь практикт хэрэгжих явцад дараах хүндрэл, зөрчил үүсгэж байна.

Нэгдүгээрт, тэтгэвэр тогтоолгосон иргэд хөдөлмөр эрхэлж байгаа бодит байдалд нийгмийн даатгалын харилцаанд идэвхтэй оролцож байгаа боловч тэдгээрийн даатгалын статус тодорхой бус, хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдсан.

Хоёрдугаарт, тэтгэвэр авагчид цалин орлогоосоо тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх эсэх асуудал нь хуульд тодорхой бус зохицуулагдсан тул зарим тохиолдолд албан журмаар шимтгэл төлүүлж, зарим тохиолдолд чөлөөлөх, эсхүл байгууллага бүр өөрөөр тайлбарлан хэрэглэх нөхцөл үүссэн.

Гуравдугаарт, тэтгэвэр авагчийн хөдөлмөр эрхлэх сонирхолд нийгмийн даатгалын шимтгэлийн зохицуулалт шууд нөлөөлж байгаа бөгөөд тодорхой бус, ялгавартай зохицуулалт нь хөдөлмөр эрхлэлтийг сааруулах, албан бус хөдөлмөрийг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна.

Иймд тэтгэвэр авагчийн нийгмийн даатгалд хамрагдах эсэх зохицуулалтыг илүү тодорхой, нэг мөр болгохгүй бол практикт хэрэгжих явцад үүссэн бодит хүндрэл, зөрчил, эдийн засгийн сөрөг нөлөөллийг үүсгэж байгаа тул уг зохицуулалтыг боловсронгуй болгох практик хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Монгол Улсад 2025 оны жилийн эцсийн байдлаар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, ажил хөдөлмөр эрхэлж байгаа 62.2 мянган тэтгэвэр авагчаас 33.1 мянга нь одоогийн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.6 дахь хэсэгт заасны дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдсөн байна. Энэ нь нийт ажиллаж буй өндөр насны тэтгэвэр авагчдын 53.2 хувийг, харин үлдсэн 29.1 мянга нь уг заалтын болзол хангаагүй тул шимтгэл төлсөн, ялгавартай нөхцөл байдалд өртсөн иргэд нь 46.8 хувь байна. Эдгээр 29.1 мянган тэтгэвэр авагч нийт 108.8 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлснөөс:

- 95.8 тэрбум төгрөг нь тэтгэврийн даатгал,
- 10.1 тэрбум төгрөг нь тэтгэмжийн даатгал,
- 2.9 тэрбум төгрөг нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал байна. Эндээс харахад нийт төлсөн шимтгэлийн 88.1 хувь нь зөвхөн тэтгэврийн даатгалын шимтгэл эзэлж байна.

Дэлхийн улс орнуудын нийгмийн даатгалын тогтолцоонд тэтгэвэр авагчийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлд шимтгэлээс бүрэн чөлөөлөх, сайн дурын шимтгэлийн, хязгаарлагдмал шимтгэлийн гэсэн 3 үндсэн түгээмэл загвараар хэрэгжүүлдэг байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2 зүйлтэй байхаар боловсруулна.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн “7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1-д заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн

өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.” гэж өөрчлөхөөр тусгана.

Энэхүү зохицуулалт нь Нийгмийн даатгалын ерөнхий хуульд тэтгэвэрт гарсан иргэдийг насны хязгаараар ялгаварлан тэтгэврийн даатгалын шимтгэл төлүүлж байгаа заалтын хамрах хүрээг өргөсгөх, ялгаварлал үүсгэхгүй байх боломжийг бүрдүүлнэ. Мөн цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн хамрагдах, Хөдөлмөрийн тухай хууль болон Ахмад настны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх юм.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлд хуулийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх хугацааг зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар тэтгэврийн даатгалын сангийн орлого 95.8 тэрбум төгрөгөөр буурах бөгөөд энэ хэмжээг улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр нөхөх шаардлага үүснэ. Гэвч энэхүү өөрчлөлт нь богино хугацаанд төсвийн зардал нэмэгдүүлэх хэдий ч дунд болон урт хугацаанд нийгэм, эдийн засгийн эерэг үр нөлөө бий болгоно.

Тодруулбал, дараах эерэг үр дагаврыг бий болгоно гэж тооцоолж байна:

3.1.Хуулийн төсөл батлагдсанаар одоо шимтгэл төлж байгаа 29.1 мянган тэтгэвэр авагч тэтгэврийн даатгалын шимтгэлээс бүрэн чөлөөлөгдөнө.

3.2.Ахмад настны бодит орлого сард дунджаар 274 мянган төгрөгөөр нэмэгдэж бага, дунд орлоготой ахмадуудад мэдэгдэхүйц дэмжлэг болно. Ялангуяа өрхийн бусад орлого сул, эмчилгээний зардал өндөр нөхцөлд энэ нь амьжиргаанд шууд нөлөөлнө.

3.3.Ахмад настны хөдөлмөр эрхлэлт ойролцоогоор 5 хувиар өсөж, 3–4 мянган иргэн шинээр хөдөлмөр эрхлэх боломж бүрдэнэ. Тэтгэврийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдсөнөөр 52.5 тэрбум төгрөгийн орлого ахмад настанд үлдэж, 56.3 тэрбум төгрөгийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх дарамт ажил олгогчийн хувьд буурна, энэ нь улмаар эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэх замаар нийтдээ 130.0–140.0 орчим тэрбум төгрөгийн эдийн засгийн үр өгөөж бий болгох боломжтой байна.

3.4.Албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд тэтгэвэр авагчид шимтгэлийн дарамтаас зайлсхийх зорилгоор албан бус хэлбэрээр ажиллах сонирхолтой байдаг бол ажил олгогчийн төлөх шимтгэлийн ачаалал буурснаар илүү албан ёсны гэрээ, хөдөлмөрийн харилцаанд орох хөшүүрэг болно. Энэ нь хөдөлмөрийн эрх зүйн хамгаалалт сайжрах, ахмад настны хөдөлмөр эрхлэлт өсөж хүн амын орлогын албан татварт 10.0-15.0 тэрбум төгрөгийн нэмэлт төсвийн орлого бүрдэх олон эерэг талтай.

Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тосцох тухай хууль тогтоомжийн талаар.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд уг хуулийн төсөлтэй холбогдуулан нэмэлт оруулах хуулийн төсөл байхгүй болно.

ТАНИЛЦУУЛГА /товч/

"Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийн тухай

Дэлхийн хүн амд 65 ба түүнээс дээш насны ахмадууд 2024 онд 10 хувийг эзэлж байгаа ба 2030 онд 12 хувь буюу 994 сая, 2050 онд 16 хувь буюу 1.6 тэрбум болж өснө¹. Монгол Улсын хувьд 60 ба түүнээс дээш насны ахмад настны тоо 2000 онд нийт хүн амын 5.4 хувь, 2010 байдлаар 5.8 хувь, 2021 оны байдлаар 9.7 хувь, 2024 оны байдлаар 11.8 хувьд хүрч байгаа бол 2030 онд 11.9 хувь, 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш настай болох магадлалтайг Үндэсний статистикийн хорооноос тооцоолжээ.

Манай улсад хүн амын дундаж наслалт 2024 оны байдлаар 71.8 (Үүнээс: эрэгтэй 67.9 нас, эмэгтэй 77.1 нас)-д хүрч, дундаж насны зөрүү 9.2 жил байна. 2025 оны байдлаар Монгол Улсад нийт хүн амын 11.8 хувь буюу 406.2 мянган ахмад настан байна.

Хүн амын дундаж наслалт тогтмол нэмэгдэж улмаар хөдөлмөрийн насны хүн амд ноогдох ахмад настануудын тоо 2010 онд 10 хүн тутамд 1 байсан бол, 2040 он гэхэд 4 хүн тутамд 1 болохоор байна. Өөрөөр хэлбэл хүн ам насжихын хирээр залуу ажилчдын эзлэх хувь буурах тул мэдлэг чадвартай, ажил амьдралын туршлагатай ахмад ажилчдын хөдөлмөр эрхлэлтийг зохистой хэлбэрээр дэмжих шаардлага тулгарч Ахмад настны тухай хууль болон Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн зохицуулалт нь тэтгэвэр авагчийн нийгмийн даатгалд хамрагдах эсэх асуудлыг тодорхойлох зорилготой боловч уг зохицуулалт нь практикт хэрэгжих явцад дараах хүндрэл, зөрчил үүсгэж байна. Үүнд:

Нэгдүгээрт, тэтгэвэр тогтоолгосон иргэд хөдөлмөр эрхэлж байгаа бодит байдалд нийгмийн даатгалын харилцаанд идэвхтэй оролцож байгаа боловч тэдгээрийн даатгалын статус тодорхой бус, хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдсан.

Хоёрдугаарт, тэтгэвэр авагчид цалин орлогоосоо тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх эсэх асуудал нь хуульд тодорхой бус зохицуулагдсан тул зарим тохиолдолд албан журмаар шимтгэл төлүүлж, зарим тохиолдолд чөлөөлөх, эсхүл байгууллага бүр өөрөөр тайлбарлан хэрэглэх нөхцөл үүссэн.

Гуравдугаарт, тэтгэвэр авагчийн хөдөлмөр эрхлэх сонирхолд нийгмийн даатгалын шимтгэлийн зохицуулалт шууд нөлөөлж байгаа бөгөөд тодорхой бус, ялгавартай зохицуулалт нь **хөдөлмөр эрхлэлтийг сааруулах, албан бус хөдөлмөрийг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна.**

Иймд тэтгэвэр авагчийн нийгмийн даатгалд хамрагдах эсэх зохицуулалтыг илүү тодорхой, нэг мөр болгохгүй бол практикт хэрэгжих явцад үүссэн бодит хүндрэл, зөрчил, эдийн засгийн сөрөг нөлөөллийг үүсгэж байгаа тул уг зохицуулалтыг боловсронгуй болгох, ажил олгогчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн ачаалал буурч ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбоотой заалтуудыг тусгав.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар өнөөдрийн байдлаар тэтгэврийн даатгалын шимтгэл төлж байгаа 29.1 мянган тэтгэвэр авагч тэтгэврийн даатгалын

¹ <https://www.visualcapitalist.com/cp/charted-the-worlds-aging-population-1950-to-2100/>

шимтгэлээс бүрэн чөлөөлөгдөнө. Ажил олгогчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн дарамт буурна.

Ахмад настны бодит орлого сард дунджаар 274 мянган төгрөгөөр нэмэгдэж бага, дунд орлоготой ахмадуудад мэдэгдэхүйц дэмжлэг болно. Ялангуяа өрхийн бусад орлого сул, эмчилгээний зардал өндөр нөхцөлд энэ нь амьжиргаанд шууд нөлөөлнө. Мөн аж ахуйн нэгж байгууллагын төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн дарамт 56.3 тэрбум төгрөгөөр буурч, цаашид ахмад настны хөдөлмөр эрхлэлт ойролцоогоор 5 хувиар өсөж, 3–4 мянган иргэн шинээр хөдөлмөр эрхлэх боломж бүрдэж эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэх замаар нийтдээ 130.0–140.0 орчим тэрбум төгрөгийн эдийн засгийн үр өгөөж бий болгох боломжтой байна.

Албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд тэтгэвэр авагчид шимтгэлийн дарамтаас зайлсхийх зорилгоор албан бус хэлбэрээр ажиллах сонирхолтой байдаг бол ажил олгогчийн төлөх шимтгэлийн ачаалал буурснаар илүү албан ёсны гэрээ, хөдөлмөрийн харилцаанд орох хөшүүрэг болно. Энэ нь хөдөлмөрийн эрх зүйн хамгаалалт сайжрах, ахмад настны хөдөлмөр эрхлэлт өсөж хүн амын орлогын албан татварт 10-15 тэрбум төгрөгийн нэмэлт төсвийн орлого бүрдэх олон эерэг талтай.

ТАНИЛЦУУЛГА /дэлгэрэнгүй/

"Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийн тухай

Дэлхийн хэмжээнд төрөлтийн түвшин буурч, дундаж наслалт нэмэгдэж байгаагаас 2025 онд 65 ба түүнээс дээш насны 820 сая хүн байгаа нь 1980 оныхоос 3.1 дахин их байна. Дэлхийн хүн амд 65 ба түүнээс дээш насны ахмадууд 2025 онд 10 хувийг эзэлж байгаа ба 2030 онд 12 хувь буюу 994 сая, 2050 онд 16 хувь буюу 1.6 тэрбум болж өснө¹. Иймд дэлхийн улс, орнууд хүн ам зүйн өөрчлөлт, насжилт, ахмад настны тооны хурдацтай өсөлтийг тооцон ахмад настны хөдөлмөр эрхлэлт, нийгмийн амьдралын оролцоо, дэмжлэгийн бодлого, шийдвэрээ эргэн харж сайжруулан, санхүү төсвөө ч дорвитой нэмэгдүүлэхэд анхаардаг болсон.

Монгол Улсын хувьд ч мөн адил хүн амын насны бүтэц өөрчлөгдөж, хүн амын тоо сүүлийн 10 жилд 16.1 хувиар өссөн бол мөн хугацаанд ахмад настны тоо 21.9 хувиар буюу илүү хурдацтай өссөн байна. 2000 онд 60 ба түүнээс дээш насны иргэд нийт хүн амын 5.4 хувь, 2010 байдлаар 5.8 хувь, 2021 оны байдлаар 9.7 хувь, 2024 оны байдлаар 11.8 хувьд хүрч байгаа бол 2050 он гэхэд 5 хүн тутмын нэг нь 60 ба түүнээс дээш настай болох магадлалтайг Үндэсний статистикийн хорооноос тооцоолсон. Энэ хүрээнд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа-2050"-д зорилтот бүлгийн иргэдийг дэмжсэн, бүтээмжтэй ажил, хөдөлмөр эрхлүүлэх, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, хүн амын бүлгүүд, тухайлбал: эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгох гэж тусгагдсан.

Энэхүү урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ нь хязгаарлагдмал, хамрагдалт бага байна. Тухайлбал, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 2025 онд ахмад настны зөвлөх үйлчилгээнд 1109 ахмад хамрагдаж, 1,065.7 сая төгрөг, эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 1094 ахмад хамрагдаж 7,586.5 сая төгрөг, хүүхэд хамгаалагч үйлчилгээнд 224 ахмад хамрагдаж, 324.5 сая төгрөг буюу нийт 8,976.7 сая төгрөг зарцуулжээ. Хөтөлбөрт хамрагдсан ахмад настны тоо 2022 онд 2230 ахмад настан, 2025 онд 2427 ахмад настан байгаа нь нийт ахмад настантай харьцуулахад маш бага хувийг эзэлж байна.

Хүн амын дунд ахмад настны тоо нэмэгдэж, ахмад настнууд эрт тэтгэвэрт гарч, хүн амын дундаж наслалт тогтмол нэмэгдэж улмаар хөдөлмөрийн насны хүн амд ноогдох ахмад настнуудын тоо нэмэгдэж, 2010 онд 10 ажилтан тутам нэг ахмад настан байсан бол, 2040 он гэхэд 4 ажилтан тутам 1 ахмад настан ногдохоор байна. Өөрөөр хэлбэл хүн ам насжихын хирээр залуу ажилчдын эзлэх хувь буурах тул мэдлэг чадвартай, ажил амьдралын туршлагатай ахмад ажилчдын хөдөлмөр эрхлэлтийг зохистой хэлбэрээр дэмжих шаардлага тулгарсаар л байна.

Иймд ахмад настны тогтвортой орлогын эх үүсвэрийг хангах зорилгоор ахмад настнуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах, улмаар ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих олон талт бодлогыг батлан хэрэгжүүлэхэд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн зохицуулалт нь практикт хэрэгжих явцад насны хязгаараар ялгаварлах дараах хүндрэл, зөрчил үүсгэж байна. Үүнд:

¹ <https://www.visualcapitalist.com/cp/charted-the-worlds-aging-population-1950-to-2100/>

Нэгдүгээрт, тэтгэвэр тогтоолгосон иргэд хөдөлмөр эрхэлж байгаа бодит байдалд нийгмийн даатгалын харилцаанд идэвхтэй оролцож байгаа боловч тэдгээрийн даатгалын статус тодорхой бус, хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдсан.

Хоёрдугаарт, тэтгэвэр авагчид цалин орлогоосоо тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх эсэх асуудал нь хуульд тодорхой бус зохицуулагдсан тул зарим тохиолдолд албан журмаар шимтгэл төлүүлж, зарим тохиолдолд чөлөөлөх, эсхүл байгууллага бүр өөрөөр тайлбарлан хэрэглэх нөхцөл үүссэн.

Гуравдугаарт, тэтгэвэр авагчийн хөдөлмөр эрхлэх сонирхолд нийгмийн даатгалын шимтгэлийн зохицуулалт шууд нөлөөлж байгаа бөгөөд тодорхой бус, ялгавартай зохицуулалт нь хөдөлмөр эрхлэлтийг сааруулах, албан бус хөдөлмөрийг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна.

Иймд тэтгэвэр авагчийн нийгмийн даатгалд хамрагдах эсэх зохицуулалтыг илүү тодорхой, нэг мөр болгохгүй бол практикт хэрэгжих явцад үүссэн бодит хүндрэл, зөрчил, эдийн засгийн сөрөг нөлөөллийг үүсгэж байгаа тул уг зохицуулалтыг боловсронгуй болгох практик хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Монгол Улсад 2025 оны жилийн эцсийн байдлаар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, ажил хөдөлмөр эрхэлж байгаа 62.2 мянган тэтгэвэр авагчаас 33.1 мянга нь одоогийн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.6 дахь хэсэгт заасны дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдсөн байна. Энэ нь нийт ажиллаж буй өндөр насны тэтгэвэр авагчдын 53.2 хувийг, харин үлдсэн 29.1 мянга нь уг заалтын болзол хангаагүй тул шимтгэл төлсөн, ялгавартай нөхцөл байдалд өртсөн иргэд нь 46.8 хувь байна. Эдгээр 29.1 мянган тэтгэвэр авагч нийт 108.8 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл төлснөөс:

- **95.8 тэрбум төгрөг** нь тэтгэврийн даатгал,
- **10.1 тэрбум төгрөг** нь тэтгэмжийн даатгал,
- **2.9 тэрбум төгрөг** нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал байна. /Хүснэгт №1/

Эндээс харахад нийт төлсөн шимтгэлийн **88.1 хувь** нь зөвхөн тэтгэврийн даатгалын шимтгэл эзэлж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэгт өндөр насны тэтгэврийн нас нь 65 нас (энэ насыг 2018 оноос жил бүр 3 сараар нэмэгдүүлэн 65 нас хүргэнэ)-нд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч нь ажил олгогч, хүнтэй хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа тохиолдолд тэтгэврийн даатгалд даатгуулахгүй байж болохоор зохицуулсан.

**Ажил олгогч, хүнтэй хөдөлмөрийн гэрээ, ажил
гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах
гэрээний дагуу ажиллаж байгаа өндөр насны тэтгэвэр
авагчийн судалгаа²**

Хүснэгт №1

Д/д	Даатгуулагчийн төрөл	Хүний тоо	Цалингийн сан, тэрбум.төг	Нийгмийн даатгалын шимтгэл, тэрбум.төг	Үүнээс: Тэтгэврийн даатгалын шимтгэл, тэрбум.төг
НДЕХ-ийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасан болзлыг хангаагүй өндөр насны тэтгэвэр авагч					
1	Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтан	27,868	536.8	103.6	91.3
2	Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон ажилтан	1,223	26.7	5.2	4.5
Дүн		29,091	563.5	108.8	95.8
НДЕХ-ийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасан болзлыг хангасан өндөр насны тэтгэвэр авагч					
1	Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтан	30,247	522.7	12.0	-
2	Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон ажилтан	2,886	66.3	1.5	-
Дүн		33,133	589.0	13.5	-
Нийт дүн		62,224	1,152.5	122.3	95.8

Нийгмийн даатгалын шимтгэлийг сан тус бүрээр авч үзвэл тэтгэврийн даатгалд 95.8 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалд 10.1 тэрбум, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд 2.9 тэрбум төгрөгийг тус тус төлсөн хэвээр байна.

Иймд хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэгт өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бүх тэтгэвэр авагчдыг хамааруулах бөгөөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 95.8 тэрбум төгрөгөөр буурах бөгөөд энэ хэмжээгээр тэтгэврийн даатгалын санд олгох улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нэмэгдэнэ.

Гэсэн хэдий ч ахмад настны тогтвортой орлогын эх үүсвэрийг хангах зорилгоор ахмад настнуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах, ахмад настнууд өөрийн чадавхыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах, тэдний мэргэжил, туршлага, ур чадварт түшиглэж залуу үеийг сургах, нөгөө талаар ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байх сайн дурын сонголтыг бүх насны тэтгэвэр авагч иргэнд хамааруулах улмаар ажил олгогчийн төлөх

² Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээ, 2026 он

тэтгэврийн даатгалын шимтгэлийн ачаалал буурах ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих заалтуудыг тусгав.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хууль боловсронгуй болж, хуулийн зохицуулалт сайжирч, эрх зүйн харилцаанд тодорхой өөрчлөлт гарах чухал нөлөө ач холбогдолтой бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой аливаа хэлбэрээр зөрчилдөхгүй болно.

Мөн хууль санаачлагч Засгийн газрын Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн, мөн зүйлийн 2-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын үндсэн бүрэн эрхийн хүрээнд хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагааны хууль зүйн үндэслэл хангагдах юм.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар өнөөдрийн байдлаар тэтгэврийн даатгалын шимтгэл төлж байгаа 29.1 мянган тэтгэвэр авагч тэтгэврийн даатгалын шимтгэлээс бүрэн чөлөөлөгдөнө.

Ахмад настны бодит орлого сард дунджаар 274 мянган төгрөгөөр нэмэгдэж бага, дунд орлоготой ахмадуудад мэдэгдэхүйц дэмжлэг болно. Ялангуяа өрхийн бусад орлого сул, эмчилгээний зардал өндөр нөхцөлд энэ нь амьжиргаанд шууд нөлөөлнө. Мөн аж ахуйн нэгж байгууллагын төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн дарамт 56.3 тэрбум төгрөгөөр буурч, ахмад настны хөдөлмөр эрхлэлт ойролцоогоор 5 хувиар өсөж, 3–4 мянган иргэн шинээр хөдөлмөр эрхлэх боломж бүрдэж эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэх замаар нийтдээ 130–140 тэрбум төгрөгийн эдийн засгийн үр өгөөж бий болгох боломжтой байна.

Албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд тэтгэвэр авагчид шимтгэлийн дарамтаас зайлсхийх зорилгоор албан бус хэлбэрээр ажиллах сонирхолтой байдаг бол ажил олгогчийн төлөх шимтгэлийн ачаалал буурснаар илүү албан ёсны гэрээ, хөдөлмөрийн харилцаанд орох хөшүүрэг болно. Энэ нь хөдөлмөрийн эрх зүйн хамгаалалт сайжрах, ахмад настны хөдөлмөр эрхлэлт өсөж хүн амын орлогын албан татварт 10-15 тэрбум төгрөгийн нэмэлт төсвийн орлого бүрдэх олон зэрэг талтай.

Хуулийн төсөл дээр санал авахаар d.parliament.gov.mn УИХ-ийн цахим хуудсанд 2 сарын турш байршуулсан бөгөөд цахимаар санал ирүүлээгүй, 358 иргэн хуулийн төсөлтэй танилцсан байна. Мөн 2026 оны 05 дугаар сарын 26-ны өдөр 200 гаруй ахмадуудад хэлэлцүүлэг хийж, холбоотой санал ирүүлээгүй, бүрэн дэмжсэн болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.6.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1-д заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэн өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 20 ... оны дугаар сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН
ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2026 ОН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгосон. Үүний нэгэн илрэл нь иргэдийн хөдөлмөрлөх болон түүнтэй холбогдсон нийгмийн хамгааллын эрхийн баталгааг хангах явдал бөгөөд энэ хүрээнд 1995 оноос даатгуулагч бүр хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоосоо тодорхой хувь хэмжээгээр шимтгэл төлж, сан бүрдүүлэх, уг сангаас төлсөн шимтгэл, авч байсан цалин хөлстэйгөө уялдаатай тэтгэвэр, тэтгэмж авах агуулга бүхий эв санааны нэгдлийн зарчимд үндэслэсэн хуваарилалтын санхүүжилттэй нийгмийн даатгалын тогтолцоог бүрдүүлсэн.

Нийгмийн даатгалын тогтолцоо нь төр, иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хууль, тогтоомжид заасан хувь хэмжээ, журмын дагуу зохих хэмжээний шимтгэл төлж, улмаар нийгмийн даатгалын сан бүрдүүлж, даатгуулагч нь өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа түр буюу урт хугацаагаар алдах, ажилгүй болох, өвчлөх тохиолдолд даатгуулагчид өөрт нь, хэрэв тухайн даатгуулагч нас барвал түүний асрамжид байсан насанд хүрээгүй, хөдөлмөрийн чадваргүй этгээдэд хууль, тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох агуулга бүхий нийгэм, эдийн засгийн шинжтэй цогц арга хэмжээ юм.

Монгол Улсын хувьд 1991 оноос өмнө нийгмийн даатгалын харилцаа нь төрийн зохицуулалт зонхилсон, дийлэнх зардал улсын төсвөөс зарцуулагддаг байсан. Харин зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн Нийгмийн даатгалын багц хуулийг 1994 онд баталж, 1995 оноос хэрэгжүүлж шимтгэлд суурилсан нийгмийн даатгалын шинэ тогтолцоо нэвтрүүлсэн нь нийгэм, эдийн засгийн хүрээнд хийгдсэн томоохон шинэчлэлийн нэг бөгөөд уг хуулиар ажил олгогчид, ажил хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр сан бүрдүүлж, уг сангаас даатгуулагчид төлсөн шимтгэл, авч байсан цалин хөлстэй нь уялдсан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал олгох тогтолцоог бүрдүүлсэн.

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.2-т “хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалыг Засгийн газар баталж мөрдүүлнэ.” гэж тус тус заасны хүрээнд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын /цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Улсын Их Хурлын 1994 оны нэгдсэн чуулганаар Нийгмийн даатгалын багц хуулийг хэлэлцэн баталж, 2023 оны нэгдсэн чуулганаар эдгээр хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлага нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалтад ажил хөдөлмөр эрхэлж байгаа өндөр насны тэтгэвэр авагч 65 насанд хүрсэн тохиолдолд өөрөө хүсвэл тэтгэврийн даатгалд даатгуулахгүй байх болохоор заасан зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулан ажил хөдөлмөр эрхэлж байгаа өндөр насны тэтгэвэр авагчийг нас харгалзахгүйгээр, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан ажил хөдөлмөр эрхэлж байгаа тэтгэвэр авагчид ижил үйлчлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэхэд оршиж байгаа юм.

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг оновчтой тогтоож, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлохоор зорилоо.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байх сайн дурын сонголтыг бүх насны тэтгэвэр авагч иргэнд хамааруулах харилцааг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бий болгох шаардлага байгаа болно.

Эрх зүйн зохицуулалт: Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д зорилтот бүлгийн иргэдийг дэмжсэн, бүтээмжтэй ажил, хөдөлмөр эрхлүүлэх, хүн амын бүлэг бүрийн онцлогт нийцсэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, хүн амын бүлгүүд, тухайлбал: эмэгтэйчүүд, оюутан, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгох гэж тусгагдсан.

Практик хэрэгжилтийн байдал: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах дараах практик хэрэгцээ шаардлага байгааг дээр дурдсан болно.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлсон байдал:

Дээр дурдсан нөхцөл байдлаас дүгнэж үзвэл, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шинэ зохицуулалт нь өндөр насны тэтгэвэр авагчийн нийгмийн хамгаалал, эрх зүйн байдалд ихээхэн дэмжлэг үзүүлж байгаа хэдий ч хууль батлагдсанаас хойших хугацаанд өндөр насны тэтгэвэрт гарсан боловч нийгмийн даатгалын шимтгэл төлөх харилцааг наснаас хамааруулан ялгавартай төлөх нөхцөлийг бүрдүүлсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн, мөн зүйлийн 2-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх

зүйн этгээд байна.” гэж заасантай зөрчилдөн сөрөг нөлөө үзүүлж байна гэж үзэх үндэстэй байна.

	Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1 дэх хэсэгт заасан насанд хүрээгүй өндөр насны тэтгэвэр авагч болон Цэргийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэвэр авагч хамаарна.	-Өндөр насны болон цэргийн тэтгэвэр авагч нь ажил хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан эрх зүйн зохицуулалт нэгэн адил үйлчлэхгүй байгаа нь сөргөөр нөлөөлж байна.

1.3. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан:

Холбогдох нөхцөл байдлыг судлан үзвэл дараах учир шалтгаантай байна. Эдгээрийг багцлан үзвэл:

- Тэтгэвэр тогтоолгосон иргэд хөдөлмөр эрхэлж байгаа бодит байдалд нийгмийн даатгалын харилцаанд идэвхтэй оролцож байгаа боловч тэдгээрийн даатгалын статус тодорхой бус, хууль хэрэглээний нэгдмэл байдал алдагдсан.

- Тэтгэвэр авагчид цалин орлогоосоо тэтгэврийн даатгалын шимтгэл төлөх эсэх асуудал нь хуульд тодорхой бус зохицуулагдсан тул зарим тохиолдолд албан журмаар шимтгэл төлүүлж, зарим тохиолдолд чөлөөлөх нөхцөл үүссэн.

- Тэтгэвэр авагчийн хөдөлмөр эрхлэх сонирхолд нийгмийн даатгалын шимтгэлийн зохицуулалт шууд нөлөөлж байгаа бөгөөд тодорхой бус, ялгавартай зэрэг болно.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЬЁОЛСОН БАЙДАЛ

Эрх зүйн зохицуулалтын хувьд хуульд нэмэлт оруулж холбогдох эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан тогтоох асуудал тулгамдаж байна.

Иймд Аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилтыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилт: Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх болно.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

замаар зорилтыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх сөрөг, эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргав.

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	Тэг хувилбар	Шийдвэрлэвэл зохих асуудлыг хэвээр нь үргэлжлүүлбэл тодорхой үр дүнд хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч, асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тодорхой хэмжээнд шийдвэрлэнэ.	Үр дүн эерэг
2.	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Хэвлэл, мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан тус хууль тогтоомжийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах нь хууль тогтоомжийн талаар иргэд олон нийтийн ойлголтыг батжуулах хэдий ч асуудлыг шийдвэрлэх боломжгүй.	Хэвлэл, мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан тус хууль тогтоомжийн талаар олон нийтийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах, хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулахтай холбоотойгоор төсвөөс зардал гаргахгүй ч тодорхой хэмжээнд шийдвэрлэнэ.	Үр дүн эерэг, сөрөг
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Тус хуультай хамаарал бүхий асуудлыг зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийснээр үр дүнд хүрэх боломжгүй.	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийснээр үр дүнд хүрэхгүй.	Үр дүн сөрөг
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Төрөөс санхүүгийн интервенц хийх нь тэтгэвэр өвлөх харилцаанд чухал нөлөө үзүүлэх хэдий ч асуудлыг бүрэн шийдвэрлэхэд үр дүн муутай байна.	Төрөөс санхүүгийн интервенц хийснээр тэтгэвэр өвлөхтэй холбоотой хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх боломжтой хэдий ч эрх зүйн зохицуулалтыг бий болгохгүйгээр зохих үр дүнд хүрэхгүй юм.	Үр дүн сөрөг
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх асуудлыг төрийн бус байгууллага, хувийн хэвшлээс шууд гүйцэтгүүлэх боломжгүй юм.	Хуульд нэмэлт оруулах замаар асуудлыг шийдвэрлэхэд төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх боломжгүй юм.	Үр дүн сөрөг

6	Захиргааны шийдвэр гаргах	Хамрагдах оролцогч хариуцлагыг нэмэгдүүлэх, сайжрах нэмэгдэнэ.	хүрээ, талуудын хяналт боломж	Захиргааны акт гаргах замаар өвлөхтэй харилцааг шийдэх шаардлагагүй.	Тодорхой үр дүнд хүрнэ.
---	---------------------------	--	-------------------------------	--	-------------------------

Практик амьдралд тулгарч байгаа зарим асуудлыг хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх талаар холбогдох дүгнэлтийг хийсэн нь Аргачлалын 5.4-т “Дараах тохиолдолд хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгоно: 5.4.4-т “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийсэн үнэлгээнээс тухайн хуульд нэмэлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан бол” гэж заасантай нийцэж байх тул хуулийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгосон болно.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар нэгтгэн гаргав.

6.1.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний үнэлгээ.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ (Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг тусгахгүй.
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалтыг тусгахгүй.
	1.1.3. Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм	Тийм	Үгүй	Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ биш.

	хэмжээнд нийцэж буй эсэх			
1.2. Оролцоог хангах				
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Холбогдох зохицуулалтыг хуульд тусгахдаа эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгүүдтэй мэдээлэл хуваалцаж, оролцоог хангасан.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах боломж нэмэгдэнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Шударга, тэгш эрх, үр өгөөжтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хариуцлагатай холбоотой зохицуулалт тусгахгүй.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгахгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Зарим хориглолт, хязгаарлалтыг хуулиар тогтоохгүй.
3. Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах	Тийм	Үгүй	Нийгмийн даатгалын сангаас олгох

	бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх			тэтгэврийн тухай хуулийн 5.1.1 дэх хэсэгт заасан насанд хүрээгүй өндөр насны тэтгэвэр авагч болон Цэргийн тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэвэр авагч
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон зохицуулалт байхгүй.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзсэн үзсэн зохицуулалт агуулаагүй.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг агуулаагүй.
4. Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллага, иргэн, байгууллага үүрэг хүлээнэ.
5. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендерийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Жендерийн үзэл баримтлалтыг зохицуулалт агуулгаагүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуульд тусгах зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан нийтлэг зарчмын хүрээнд боловсруулагдана.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополыг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.

	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инновац болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

бүлийн төсөв	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Нийгмийн даатгалын сангийн орлого буурах тул энэ хэмжээгээр улсын төсвийн зардал нэмэгдэнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	10.3.Инфляц нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Бий болсон.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ажлын байранд тогтвортой ажиллах сонирхол нэмэгдэнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Алба хаагчдын үүрэг хариуцлага сайжирна.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Ажлын байрны тодорхойлолт гарна.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага нэмэгдэнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн захиргааны зарим байгууллагын албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд өөрчлөлт орохгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт,	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх			
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөө үзүүлэхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
--	---	------	------	--------------------------------

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.3.Учдны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

6.1.2.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн, мөн зүйлийн 2-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж заасан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар хууль боловсронгуй болж, хуулийн зохицуулалт сайжирч, эрх зүйн харилцаанд тодорхой өөрчлөлт гарах чухал нөлөө ач холбогдолтой бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль болон хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой аливаа хэлбэрээр зөрчилдөхгүй болно.

Мөн хууль санаачлагч Засгийн газрын Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн, мөн зүйлийн 2-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэсэн эрх зүйн зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын үндсэн бүрэн эрхийн хүрээнд хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагааны хууль зүйн үндэслэл хангагдах юм.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ ХИЙСЭН БАЙДАЛ

Аргачлалын 7-д зааснаар хувилбаруудын эерэг болон сөрөг талуудыг

-Зорилгод хүрэх байдал;

-Зардал, үр өгөөжийн харьцаа;

-Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;

-Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;

-Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Эрх зүйн орчныг сайжруулахын тулд боловсруулсан зохицуулалтуудын хувилбарт хүний эрхийг зөрчсөн зохицуулалт тусгагдаагүй болно.

Эдийн засгийн үр нөлөө, нийгэмд үзүүлэх үр нөлөө, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөний хувьд ямар нэгэн сөрөг үр нөлөө байхгүй, төрийн байгууллагын үүрэг, хариуцлага улам нэмэгдэнэ.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлд 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэсэн, мөн зүйлийн 2-д “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэсэн эрх зүйн зохицуулалт хангагдана.

Иймд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Монгол улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” 181 дүгээр тогтоолын 3-т “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч хууль тогтоомжоор зохицуулах зайлшгүй шаардлагатай хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.” гэж заасны хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дээрх харьцуулалтын үр дүнг харгалзан үзэж, тулгамдаж байгаа асуудлыг цогцоор шийдвэрлэх боломжийн хувьд дэвшүүлсэн хувилбарыг тус хуульд тусгаж, тус хуулийг төслийг хуульд нэмэлт оруулах замаар боловсруулан хуулийг батлан хэрэгжүүлэх хувилбар илүү үр дүнд хүрэх юм.

---oOo---

Эх сурвалж:

Монгол Улсын хуулиуд

Гэр бүл, хөдөлмөрийн яамны албан мэдээлэл

Нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээлэл

OECD. (2017). *Model tax convention on income and on capital: Condensed version 2017*. OECD Publishing. <https://www.oecd.org/tax/treaties/model-tax-convention-on-income-and-on-capital-condensed-version-20745419.htm>

OECD. (2021). *Model tax convention on income and on capital 2021 full version*. OECD Publishing. <https://www.oecd.org/tax/treaties/model-tax-convention-on-income-and-on-capital-full-version-57a089d7.htm>

OECD. (2025). *The 2025 update to the OECD model tax convention*. OECD Publishing. <https://www.oecd.org/tax/treaties/>

OECD. (n.d.). *OECD model tax convention on income and on capital*. <https://www.oecd.org/tax/treaties/>

Tilburg University. (2020). *Pensions (Article 18 OECD model convention)*. <https://research.tilburguniversity.edu/en/publications/pensions-article-18-oecd-model-convention-2>

Genser, B., & Holzmann, R. (2019). *The taxation of pensions: Issues, concepts and international coordination under the OECD model tax convention*. Joint Vienna Institute. https://www.jvi.org/fileadmin/jvi_files/Public_Lectures/2019/The_taxation_of_pensions_Jan17/The_Taxation_of_Pensions_Version_01012019_BGenserR_Holzmann_JVI_January_17_2019.pdf

European Union. (2024). *Double taxation: Tax rules and coordination in the EU*. https://europa.eu/youreurope/citizens/work/taxes/double-taxation/index_en.htm

Tax Adviser Magazine. (2023). *Moving abroad: The impact of double tax treaties on UK pension payments*. <https://www.taxadvisermagazine.com>

DIVA Portal. (2020). *Allocation of taxing rights of occupational pensions in OECD model tax convention*. <https://www.diva-portal.org/smash/get/diva2:1437457/FULLTEXT01.pdf>

**ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР
НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

**Улаанбаатар хот
2026 он**

АГУУЛГА

УДИРТГАЛ	2
НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ.....	3
ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ	3
2.1. Зорилгод хүрэх байдал.....	3
2.2. Практикт хэрэгжих боломж.....	4
2.3. Ойлгомжтой байдал.....	4
2.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал.....	4
2.5. Зардал	4
2.6. Харилцан уялдаа	4
ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ	4
3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	6
3.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	8
3.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	8
3.4. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	9
3.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	9
ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ	11
4.1. Дүгнэлт.....	11
4.2. Зөвлөмж.....	11

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ын 2.6.16-т “Хүн амын бүлгүүд, тухайлбал ...ахмад настан хагас цагаар, гэртээ, зайнаас ажиллах уян хатан зохицуулалт бий болгоно.”, 3.1.13-т “Ахмад настанд урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэх хөгжлийн төвүүдийг байгуулна.”, 3.1.18-т “Ахмад настанд ... үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлнэ.” гэж тусгасан.

Энэ хүрээнд 2017 оны 1 дүгээр сарын 26-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн “Ахмад настны тухай” хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд холбогдох судалгааг хийсэн.

Уг судалгаагаар Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, ахмад настны тусламж үйлчилгээний нэгдсэн, цогц тогтолцоог бүрдүүлэх зорилтыг эрчимжүүлэх, насжилтын үеийн өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг хүчин зүйлүүдийг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ахмад настныг ажлын байраар хангаж байгаа ажил олгогч, аж ахуйн нэгжүүдийг татварын болон бусад бодлогоор дэмжих, ахмадын асрамж, хамгаалал, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагаа өнгөрүүлэх орчин нөхцөлийг бий болгох асуудлаар цогц бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэх, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхийг зорьсон болно.

АХМАД НАСТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Энэхүү үнэлгээг “Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

“Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн /цаашид “хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал” - /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийсэн.

1. Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх;
4. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс 5 шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал
2. Практикт хэрэгжих байдал
3. Ойлгомжтой байдал
4. Зардал
5. Харилцан уялдаа зэрэг болно.

2.1. Зорилгод хүрэх байдал

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх /бүрэн илэрхийлж чадсан эсэх/, хуулийн төслийн үндсэн зорилго нь Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Ахмад настны хууль хэрэгжиж эхэлснээс хойш уг хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд тэтгэвэрт гарсан иргэн ажил, хөдөлмөр эрхлэхэд тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхөд зарим саад бэрхшээл тулгарч байгаа тул уг шалтгааныг эрт илрүүлэх, цаашид хуулийг боловсронгуй болгоход чиглэгдэж байгааг анхаарч, хуулийн төслийн зохицуулалт, арга хэмжээ нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байна уу гэдгийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхийн тулд хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл,

шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авав.

2.2. Практикт хэрэгжих боломж

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг, мөн хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх вэ гэдгийг тогтоох, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлэх шалгуур үзүүлэлт юм.

2.3. Ойлгомжтой байдал

Хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

2.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөлд тодорхой этгээдүүдэд үүрэг хүлээлгэсэн, аж ахуйн нэгж, байгууллагын салбарт хүндрэл үүсгэх зохицуулалтыг тусгаагүй, хуулийн үйлчлэлд хамаарах оролцогч талуудтай хэлэлцүүлэг хийж, саналыг авсан тул хүлээн зөвшөөрөгдөх байдал гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авах шаардлагагүй гэж үзэв.

2.5. Зардал

Хуулийн төсөл нь төрийн байгууллага, хуулийн этгээдэд холбогдох зардал үүсгэхээр зохицуулсан байх тул уг хоёр субъектэд үүсэх зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцохоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгов.

2.6. Харилцан уялдаа

Хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Зөрчлийн тухай зэрэг холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцов.

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Энэ хэсэгт хуулийн төслөөс үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгон авлаа. Энэхүү зүйл заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс хуульд нэмэлтээр орж буй голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгож буй зүйл заалтын үр нөлөөг судлах болно.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдлыг шалгуур үзүүлэлт тус бүрээр авч үзвэл:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад хуулийн төслийн зорилго, зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа

эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийнэ.

Улс орны нийгэм, эдийн засгийн байдал, хүн амын бүтцийн өөрчлөлт, дундаж наслалт, хөдөлмөрийн харилцааны хэв шинжийн өөрчлөлттэй холбоотойгоор нийгмийн даатгалын харилцаа нь удаан хугацаанд нэг хэв маягаар үргэлжлэх нь боломжгүй болж байна. Иймд дэлхийн бусад улсын адил манай улс дээрх өөрчлөлтөөс хамаарч нийгмийн даатгалын тогтолцооны болон параметрийн шинэчлэлийг үе шаттай, аажмаар буюу даатгуулагч, ажил олгогч, тэтгэвэр авагч, улсын төсөвт ачаалал багатайгаар хийж ирсэн.

Улсын Их Хурлаас Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг 2023 онд баталж, 2024 оноос хэрэгжүүлж байна. Багц хуулийн шинэчилсэн найруулгаар ажлын байраа хадгалсан, хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсэн ажил олгогчид үзүүлэх шимтгэлийн хөнгөлөлтийн хэмжээг нэмэх, ажил олгогчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг ажлын байрнаас хамааран ялгаатай төлөх, илүү ажилласан жил тутам тэтгэвэр бодох хувийг нэмэгдүүлэх, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр тэтгэвэртээ гарсан ахмад настны тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байх заалт зэрэг шинэчлэлийг үе шаттай хэрэгжүүлэхээр заасан байна.

Мөн Ахмад настны тухай хуулийн өөрчлөлтөөр ахмад настны эдлэх эрхийг хуульчлан баталгаажуулж, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ахмад настны нийгмийн хамгааллын талаар урд өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрсэн түвшнийг сайжруулсан, хамрах хүрээг өргөжүүлсэн олон чухал заалтуудыг нэмж тусгаснаараа олон улсын байгууллагаас тогтоосон хэм хэмжээнд нийцсэн бодлогын чухал баримт бичиг болсон.

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан үндэслэл, хэрэгцээ шаардлагаас дүгнэвэл хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээс хойш уг хуулийг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд зарим саад бэрхшээл тулгарч байгаа тул уг шалтгааныг эрт илрүүлэх, давхар, хийдэл, зөрчлийг арилгах, цаашид хуулийг боловсронгуй болгоход хуулийн төслийн зорилго чиглэгдэж байна.

Аливаа хуулийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн байх ёстой учраас нэн түрүүнд хуулийн төслийн зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлага, үндэслэл болон зорилготой харьцуулан байдлаар үнэлсэн.

“Практикт хэрэгжих боломж” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн нэр томъёоны тодорхойлолт тусгасан хуулийн төслийн нэмэлт өөрчлөлт оруулсан хэсэг бүрийг сонгож авлаа.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл нь боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт болон Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг, түүнчлэн хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдүүд хуулийг ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байдлаар боловсруулагдсан эсэхийг шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь сонгон авлаа.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг хүснэгтийн дагуу тогтоолоо. Үүнд:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх
2.	Практикт хэрэгжих байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Холбогдох зохицуулалтын практик нөхцөл байдалд шинжилгээ хийх
3.	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах
4.	Зардал	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын дагуу тусад нь тооцно.	Тооцоолон гаргах
5.	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгуудаар шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд томъёолсон зорилго, зорилт болон зохицуулалттай харьцуулан үзлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалаас хүн ам зүйн өөрчлөлтийн улмаас нийт хүн амын дунд ахмад настнуудын эзлэх хувь хурдацтай өсөж байгаатай уялдуулан ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг дэмжих, хууль хоорондын зөрчлийг бууруулах, нэгдсэн ойлголтод хүргэх, улмаар ахмад настны өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд хуулийн төслийн зорилго оршиж байна.

Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу төслийн үр нөлөөг үнэлсэн байдал

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилгыг хангах эсэхийг судлах.

2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 1, 2 дугаар зүйл	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт нь бодит байдал дээр хэрэгжих боломжтой эсэхийг судлах.
3	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйл, холбогдох аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэх.
4	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хуулийн төсөлд тавигдах нийтлэг шаардлагыг хангасан эсэх.

Хуулийн төслийн зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгыг хангахад чиглэсэн эсэх, тэдгээр нь зорилгыг хангах боломжтой байдлаар томъёологдсон эсэхийг үнэлэхээр хуулийн төслийн зорилгыг сонгож дүн шинжилгээ хийлээ.

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн “5.1.1” гэснийг “5.1” гэж өөрчилсүгэй.

Ахмад настны тогтвортой орлогын эх үүсвэрийг хангах зорилгоор ахмад настнуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах, ахмад настнууд өөрийн чадавхыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах, тэдний мэргэжил, туршлага, ур чадварт түшиглэж залуу үеийг сургах, нөгөө талаар ахмад настан бүх нийтийн үйл хэрэгт идэвхтэй оролцох оролцоог дэмжин ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих шаардлага байна.

Мөн ахмад настны хөдөлмөрлөх эрх зүйн орчныг нарийвчлан тодорхойлоогүйн улмаас насаар ялгаварлан гадуурхагдах, өөрөө хүсээгүй ч эрт тэтгэвэрт гаргах, ахмад настны цалин хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцох зэрэг үйлдлүүд гарсаар байна. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор **ахмад настан өөрөө нийгмийн даатгалын шимтгэл төлөх шаардлагагүй гэж үзвэл** тухайн ахмад настныг авч ажиллуулж байгаа байгууллага тэтгэврийн даатгалын шимтгэл **8.5 хувийг төлөхгүй байх**, 50 ба түүнээс дээш ажиллагсадтай аж ахуйн нэгжийн 4-өөс доошгүй хувьд ахмад настан авч ажиллуулах, мод, хүнсний ногоо тарих зэрэг байгаль орчны болон хүнс үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн салбарт ахмад настныг ажиллахыг дэмжиж хөнгөлөлттэй зээл олгох, цалин хөлсийг зах зээлийн ханшаар ажилласан хугацаанд тооцон цагаар, өдрөөр гэх мэт уян хатан хэлбэрээр олгох, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээг өргөжүүлэх хуулийн зохицуулалт байгаа хэдий ч бүрэн хэрэгжихгүй байна.

Учир нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч өөрөө хүсвэл энэ хуулийн 6.1.1-д заасан нийгмийн даатгалын төрөлд даатгуулахгүй байж болно” гэж тусгасан хэдий ч Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан тэтгэвэр авагч гээд насны хязгаар тавьсан нь практикт зөрчил үүсгээд байна.

Монгол Улсад 2025 оны жилийн эцсийн байдлаар өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, ажил хөдөлмөр эрхэлж байгаа 62.2 мянган тэтгэвэр авагчаас 33.1 мянга нь одоогийн Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.6 дахь хэсэгт заасны дагуу тэтгэврийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдсөн байна. Энэ нь нийт ажиллаж буй

өндөр насны тэтгэвэр авагчдын 53.2 хувийг, харин үлдсэн 29.1 мянган тэтгэвэр авагч нь уг заалтын болзол хангаагүй тул шимтгэл төлсөн хэвээр, ялгавартай нөхцөл байдалд өртсөн иргэд нь 46.8 хувь байна.

Иймд энэхүү хуулийн төслийн 1 дүгээр зүйлд Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7.6-д заасан "...Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн "5.1.1" гэснийг "5.1" гэж хамрах хүрээ өргөжүүлж, ялгавартай байдлыг арилгах зохицуулалт болжээ.

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн "насанд хүрсэн" гэснийг хасаж, мөн хэсэгт "болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон" гэж нэмсүгэй.

Ахмадын сантай холбоотой хариуцлагын заалт оруулснаар аж ахуйн нэгж, байгууллагууд хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх, тухайн харилцааг хэрхэн хэрэгжүүлэх ойлголтыг бататгасан байна.

3 дугаар зүйл. Энэ хуулийг дагаж мөрдөхтэй холбогдуулан нийгмийн даатгалын байгууллага, ажил олгогч нь холбогдох журам, зааврыг шинэчлэн боловсруулж, хэрэгжилтийг хангана.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

3.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хүн ам насжихын хирээр залуу ажилчдын эзлэх хувь буурах тул мэдлэг чадвартай, ажил амьдралын туршлагатай ахмад ажилчдын хөдөлмөр эрхлэлтийг зохистой хэлбэрээр дэмжихийн тулд ахмад настнуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах, ахмад настнууд өөрийн чадавхыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах, тэдний мэргэжил, туршлага, ур чадварт түшиглэж залуу үеийг сургах, нөгөө талаар ахмад настан бүх нийтийн үйл хэрэгт идэвхтэй оролцох олон талт бодлогыг батлан хэрэгжүүлэх хүрээнд ахмад настан ажил эрхэлсэн тохиолдолд тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байхаар хуулийн төсөлд оруулсан нь тодорхой эерэг үр дүн гарахаар байна.

3.3. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Ойлгомжтой байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл боловсруулалтын хувьд Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг гүйцэтгэлээ.

Эдгээрээс үзэхэд хуулийн төслийн бүтэц, хэлбэр, эх бичвэрийн агуулга, хэл зүй, эшлэл, найруулгад тавих нийтлэг шаардлага хангагдсан байна.

3.4. “Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг “Аргачлал батлах тухай” Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлалын дагуу тооцлоо.

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэгт өндөр насны тэтгэвэр тогтоолгосон **бүх тэтгэвэр авагчдыг хамааруулах** бөгөөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 95.8 тэрбум төгрөгөөр буурах бөгөөд энэ хэмжээгээр тэтгэврийн даатгалын санд олгох улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нэмэгдэнэ.

Гэсэн хэдий ч ахмад настны тогтвортой орлогын эх үүсвэрийг хангах зорилгоор ахмад настнуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах, ахмад настнууд өөрийн чадавхыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах, тэдний мэргэжил, туршлага, ур чадварт түшиглэж залуу үеийг сургах, нөгөө талаар ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байх сайн дурын сонголтыг **бүх насны тэтгэвэр авагч иргэнд хамааруулах улмаар ажил олгогчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн ачаалал буурах ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих заалтуудыг тусгав.**

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар өнөөдрийн байдлаар тэтгэврийн даатгалын шимтгэл төлж байгаа 29.1 мянган тэтгэвэр авагч тэтгэврийн даатгалын шимтгэлээс бүрэн чөлөөлөгдөнө.

Ахмад настны бодит орлого сард дунджаар 274 мянган төгрөгөөр нэмэгдэж бага, дунд орлоготой ахмадуудад мэдэгдэхүйц дэмжлэг болно. Ялангуяа өрхийн бусад орлого сул, эмчилгээний зардал өндөр нөхцөлд энэ нь амьжиргаанд шууд нөлөөлнө. Мөн аж ахуйн нэгж байгууллагын төлөх тэтгэврийн даатгалын шимтгэл буурч ахмад настны хөдөлмөр эрхлэлт ойролцоогоор 5 хувиар өсөж, 3–4 мянган иргэн шинээр хөдөлмөр эрхлэх боломж бүрдэж эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэх замаар нийтдээ 130–140 тэрбум төгрөгийн эдийн засгийн үр өгөөж бий болгох боломжтой байна.

Албан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүрээнд тэтгэвэр авагчид шимтгэлийн дарамтаас зайлсхийх зорилгоор албан бус хэлбэрээр ажиллах сонирхолтой байдаг бол ажил олгогчийн төлөх шимтгэлийн ачаалал буурснаар илүү албан ёсны гэрээ, хөдөлмөрийн харилцаанд орох хөшүүрэг болно. Энэ нь хөдөлмөрийн эрх зүйн хамгаалалт сайжрах, ахмад настны хөдөлмөр эрхлэлт өсөж хүн амын орлогын албан татварт 10-15 тэрбум төгрөгийн нэмэлт төсвийн орлого бүрдэх олон эерэг талтай.

4.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзлээ. Хуулийн төслийн уялдаа холбоо /Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх/

Д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1.	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм	Нийцсэн

2.	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Тийм	Нийцсэн
3.	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Тийм	Нийцсэн
4.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	Нийцсэн
5.	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	Давхардаагүй
6.	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	Тусгасан
7.	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	Орхигдуулаагүй
8.	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	Давхардаагүй
9.	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй	Тусгаагүй
10.	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	Тусгаагүй
11.	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Үгүй	Тусгаагүй
12.	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хязгаарлаагүй
13.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Үгүй	Хөндөөгүй
14.	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Тусгаагүй
15.	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Тусгаагүй
16.	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм	Тусгаагүй

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Дүгнэлт

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”-ын дагуу тооцож дараах дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Зорилгод хүрэх шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийг боловсруулах болсон хэрэгцээ шаардлага, үндэслэлүүдтэй нийцэж байгаа болон үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг бүрэн илэрхийлж чадсан эсэхэд, мөн хуулийн төслийн зорилгыг уг хуулийн бусад зохицуулалтууд хангаж, илэрхийлж чадахаар бүрэн гүйцэд томъёологдсон эсэхэд үнэлгээ хийхэд зорилгодоо хүрэх байдлын шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

Үр нөлөөний үнэлгээг хуулийн төсөлд хийхэд сонгосон 4 шалгуур үзүүлэлтүүдээр хуулийн төслийн үзэл баримтлалд заасан зорилгыг хангасан, практикт хэрэгжих боломжтой, хуулийн төслийн томъёолол, зохицуулалт, найруулга нь ойлгомжтой, хоёрдмол утга санаа илэрхийлээгүй, Монгол Улсын Үндсэн хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

Иймд холбогдох аргачлалд заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, уялдаа холбоо хангагдсан гэж үзлээ.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломж байгаа эсэх, хэрэгжүүлэх субъект, байгууллага нь тодорхой эсэх, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлгээ хийхэд практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтээр:

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж, хоёрдмол утгатай үг хэллэг, хүч оруулсан үг хэллэг, ойлголтын зөрүү үүсэхээр томъёолсон байдал зэрэг асуудал тогтоогдоогүй тул ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтэд нийцсэн гэж дүгнэж байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтээр:

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуултад хариулах байдлаар шалгахад харилцан уялдаатай байдлыг хангасан гэж дүгнэж байна.

4.2. Зөвлөмж

Тус үр нөлөөг тооцох үнэлгээг Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хийв.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан үзэхэд шалгуур үзүүлэлтүүдийн хувьд бүгд нийцсэн хэмээн дүгнэгдсэн тул хуулийн төслийг зохих хууль тогтоомжид нийцүүлэн Улсын Их Хуралд өргөн барьж, хэлэлцүүлэн батлуулах шаардлагатай хэмээн зөвлөж байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Нэг. Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хууль¹-ийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий хууль²-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад гүйцэтгэх нь тухайн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр хүрэхийг хүссэн үр дүн, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход зарцуулах зардлын харьцааг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр үүсэх зардлын ачааллыг урьдчилан тооцож, цаашид гарах зардлыг багасгах санал боловсруулахад оршино.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;³
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;⁴
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;⁵
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.⁶

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг (1) төрийн байгууллагын зардал, (2) хуулийн этгээдийн зардал, (3) иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог. Харин тус хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад зардал үүсгэх зохицуулалт тусгагдаагүй тул аливаа нэмэлт болон шинэ зардал гарахааргүй байна.

Хоёр. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо

¹ 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт, өөрчлөлт орсон Хууль тогтоомжийн тухай Монгол Улсын хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=11119>

² 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдаж, 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон Монгол Улсын Нийгмийн даатгалын ерөнхий хууль <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760148379551>

³ Аргачлалын 2.3, 4.3 дахь хэсэг

⁴ Аргачлалын 2.4.4, 4.4 дэх хэсэг

⁵ Аргачлалын 4.4.3.1 дэх дэд заалт

⁶ Аргачлалын 2.1, 4.1 дэх хэсэг

Энэ хэсэгт хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолно. Ийнхүү үүсэх зардлыг аргачлалын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцоолдог. Үүнд:

- 2.1.хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.нэг бүрийн зардлыг тооцох;
- 2.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 2.5.хялбарчлах боломжийг шалгах;
- 2.6.нэмэлт зардлыг тооцох.

1. Хуулийн этгээдийн зардлын тооцоо:

Ажил хөдөлмөр эрхэлж байгаа өндөр насны тэтгэвэр авагчийг нас харгалзахгүйгээр, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан тэтгэвэр авагч ажил хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд өөрөө хүсвэл тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байх зохицуулалтыг тусгасан байна. Эдгээр зохицуулалтын үр дүнд нийгмийн даатгалын шимтгэл 108.8 тэрбум төгрөгөөр буурах бөгөөд үүнээс 56.3 тэрбум төгрөг нь ажил олгогчийн төлөх шимтгэлийн зардлын бууралт байна.

Гурав. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлын тооцоо

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг аргачлалын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу дараах дарааллыг баримтлан тогтооно. Үүнд:

- 3.1.иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 3.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 3.4.нийт дүнг тооцож гаргах;
- 3.5.хялбарчлах боломжийг шалгах.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд туссан дээрх заалтын нөлөөгөөр ахмад настанд нийт 52.5 тэрбум төгрөгийн хэмнэлтийг бий болгохоос гадна тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Хуулийн төслийн хүрээнд иргэн, даатгуулагчид нэмэлт зардал үүсгэх хуулийн зохицуулалт ороогүй болно.

Дөрөв. Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар улсын төсөвт үүсэх зардлын тооцоо

Аргачлалын 4.1-д зааснаар Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- 4.1.төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- 4.2.уг чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- 4.3.гаргах зардлыг урьдчилан тооцох;

4.4. зардлыг нэгтгэн тооцох;

4.5. хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулахаар тогтоосон.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэгт өндөр насны тэтгэврийн нас нь 65 нас (энэ насыг 2018 оноос жил бүр 3 сараар нэмэгдүүлэн 65 нас хүргэнэ)-нд хүрсэн өндөр насны тэтгэвэр авагч нь ажил олгогч, хүнтэй хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа тохиолдолд тэтгэврийн даатгалд даатгуулахгүй байж болохоор зохицуулсан.

Шимтгэл бууруулж буй дээрх зохицуулалтын үр дүнд 2026 онд нийт тэтгэврийн даатгалын сан 95.8 тэрбум төгрөгөөр буурч энэ хэмжээгээр улсын төсвийн санхүүжилтийн хэмжээг мөн хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлага бий болгож байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоолол

Д/д	Даатгуулагчийн төрөл	Хүний тоо	Цалингийн сан, тэрбум.төг	Нийгмийн даатгалын шимтгэл, тэрбум.төг	Үүнээс: Тэтгэврийн даатгалын шимтгэл, тэрбум.төг
НДЕХ-ийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасан болзлыг хангаагүй өндөр насны тэтгэвэр авагч					
1	Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтан	27,868	536.8	103.6	91.3
2	Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон ажилтан	1,223	26.7	5.2	4.5
Дүн		29,091	563.5	108.8	95.8
НДЕХ-ийн 7 дугаар зүйлийн 7.6-д заасан болзлыг хангасан өндөр насны тэтгэвэр авагч					
1	Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон ажилтан	30,247	522.7	12.0	-
2	Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон ажилтан	2,886	66.3	1.5	-
Дүн		33,133	589.0	13.5	-
Нийт дүн		62,224	1,152.5	122.3	95.8

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд хүний нөөц, бусад зардал нэмэгдэхгүй.

Нийгмийн даатгалын шимтгэлийг сан тус бүрээр авч үзвэл тэтгэврийн даатгалд 95.8 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалд 10.1 тэрбум, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд 2.9 тэрбум төгрөгийг тус тус **төлсөн хэвээр** байна.

Иймд хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэгт өндөр насны тэтгэвэр тогтоолгосон **бүх тэтгэвэр**

авагчдыг хамааруулах бөгөөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 95.8 тэрбум төгрөгөөр буурах /ажил олгогчийн төлөх 47.6 тэрбум, тэтгэвэр авагчийн төлөх 47.6 тэрбум төгрөг/ бөгөөд энэ хэмжээгээр тэтгэврийн даатгалын санд олгох улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийн хэмжээ нэмэгдэнэ.

Хуулийн төсөлд тусгагдсан заалтын харьцуулалт, үр нөлөө

Хүснэгт №2

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг

№	Хуучин зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалт	Өөрчлөлтийн агуулга	Үр нөлөө
1	"...5.1.1-д заасан..."	"...5.1-д заасан..."	Хамрах хүрээг өргөтгөсөн (зөвхөн 5.1.1 биш бүх 5.1-д хамааруулсан)	Илүү олон тэтгэвэр авагч хамрагдана
2	"насанд хүрсэн" гэсэн шалгууртай	"насанд хүрсэн" гэснийг хассан	Насны давхардсан, ялгавартай шалгуурыг арилгасан	Тэгш байдал хангагдана
3	Цэргийн тэтгэвэр авагч тодорхой тусгагдаагүй	"...Цэргийн алба хаагчийн тэтгэвэр... тогтоолгосон" гэж нэмсэн	Цэргийн тэтгэвэр авагчийг хамруулсан	Ялгавар арилна
4	Хязгаарлагдмал хамрах хүрээ	Өргөтгөсөн хамрах хүрээ	Бүх төрлийн тэтгэвэр авагчийг хамруулах	Хөдөлмөр эрхлэлтийн оролцоо нэмэгдэнэ
5	Зохицуулалт ойлгомжгүй, хэсэгчилсэн	Илүү тодорхой, иж бүрэн	Хуулийн хэл найруулга сайжирсан	Хэрэгжилт хялбар болно

Хуулийн 3 дугаар зүйл (шинээр нэмэгдэж буй)

№	Хуучин зохицуулалт	Шинэ зохицуулалт	Өөрчлөлтийн агуулга	Үр нөлөө
6	Тусгай хэрэгжилтийн заалт байгаагүй	Журам, зааврыг шинэчлэх үүрэг өгсөн	Хэрэгжилтийг хангах механизм нэмсэн	Бодит хэрэгжилт сайжирна

Хуулийн төсөл батлагдсанаар үүсэх санхүүгийн нөлөөлөл

Хуулийн төсөлд заасны дагуу тэтгэвэр тогтоолгосон бүх иргэдийг шимтгэлээс чөлөөлөх зохицуулалтад хамааруулбал дараах үр дүн гарна:

Төсвийн орлогод үзүүлэх нөлөө

- Тэтгэврийн даатгалын сангийн орлого: 95.8 тэрбум төгрөгөөр буурна.
- Улсын төсөвт үзүүлэх ачаалал

- Тэтгэврийн даатгалын сангийн орлого 95.8 тэрбум төгрөгөөр буурахтай холбоотойгоор тус санд олгох **улсын төсвийн санхүүгийн дэмжлэгийн хэмжээ яг энэ дүнгээр нэмэгдэнэ.**

Зардлын тооцооллын нэгдсэн хүснэгт

Хүснэгт №3

Үзүүлэлт	Хүний тоо	Нөлөөллийн дүн (Тэрбум.төг)	Тайлбар
Тэтгэврийн даатгалын шимтгэлийн алдагдал	29,091	- 95.8	Төсвөөс нөхөн санхүүжүүлэх шаардлагатай
Бусад сангуудын шимтгэлийн алдагдал	-	нөлөөлөхгүй	Тэтгэмж болон ҮОМШӨ-ний сангууд
Нийт төсвийн орлогын тасалдал	29,091	- 95.8	Жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр

Хуулийн төсөлд төрийн байгууллагад тэтгэвэрт гарсан иргэдийн ажил, хөдөлмөр эрхлэхэд төлөх шимтгэлээс чөлөөлөх хамрах хүрээг өргөтгөсөн, улсын төсөвт жилд дунджаар 95.8 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дэмжлэгийн зардал үүсэхээр байна.

Гэсэн хэдий ч ахмад настны тогтвортой орлогын эх үүсвэрийг хангах зорилгоор ахмад настнуудыг үргэлжлүүлэн хөдөлмөр эрхлүүлэхийг дэмжих, эдийн засгийн идэвхийг нь хадгалах, ахмад настнууд өөрийн чадавхыг амьдралынхаа туршид бүрэн дүүрэн ашиглах, тэдний мэргэжил, туршлага, ур чадварт түшиглэж залуу үеийг сургах, нөгөө талаар ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй байх сайн дурын сонголтыг **бүх насны тэтгэвэр авагч иргэнд хамааруулах улмаар ажил олгогчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн ачаалал буурах ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих боломжтой.**

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар өнөөдрийн байдлаар тэтгэврийн даатгалын шимтгэл төлж байгаа 29.1 мянган тэтгэвэр авагч тэтгэврийн даатгалын шимтгэлээс бүрэн чөлөөлөгдөнө. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон болон цэргийн тэтгэвэр авагчдыг тэтгэврийн даатгалын шимтгэлээс чөлөөлснөөр ажил олгогчийн зардал ажил олгогч нь ажилтны цалингийн сангаас 8.5%-ийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлдөг бол болзол хангаагүй 29.1 мянган тэтгэвэр авагч ажилтны цалингийн сан 563.5 тэрбум төгрөг байна. Үүнээс ажил олгогчийн төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийг тооцвол 56.3 тэрбум төгрөгийн шимтгэлийн дарамт буурна.

Улмаар өндөр настны тэтгэвэр тогтоолгосон боловч тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөөр байгаа иргэдийн бодит орлого сард дунджаар 274 мянган төгрөгөөр нэмэгдэж бага, дунд орлоготой ахмадуудад мэдэгдэхүйц дэмжлэг болно. Ялангуяа өрхийн бусад орлого сул, эмчилгээний зардал өндөр нөхцөлд энэ нь амьжиргаанд шууд нөлөөлнө. Цаашид аж ахуйн нэгж байгууллагын төлөх тэтгэврийн даатгалын шимтгэл буурч ахмад настны хөдөлмөр эрхлэлт ойролцоогоор 5 хувиар өсөж, 3–4 мянган иргэн шинээр хөдөлмөр эрхлэх боломж бүрдэж эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэх замаар нийтдээ 130–140 тэрбум

төгрөгийн эдийн засгийн үр өгөөж бий болох, ахмад настны хөдөлмөр эрхлэлт өсөж хүн амын орлогын албан татварт 10-15 тэрбум төгрөгийн нэмэлт төсвийн орлого бүрдэх олон эерэг талтай байна.

---oOo---

Хууль санаачлагын үйлчилгээ



УИХ-ын гишүүн
Аюушгийн АРИУНБАГА



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 ОНЫ 3 Р САРЫН 31 ӨДӨР

УЛААНБААТАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ӨРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн "5.1" гэснийг "5.1" гэж өөрчилсүгэй.



2 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийн "насанд хүрсэн" гэснийг хасч, мөн хэсэгт "болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон" гэж нэмсүгэй.



3 дүгээр зүйл. Энэ хуулийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.



4 дүгээр зүйл. Энэ хуулийг дагаж мөрдөхтэй холбогдуулан нийгмийн даатгалын байгууллага, ажил олгогч нь холбогдох журам, зөврийг шинэчлэн боловсруулж, харагжилтийг хангана.



✓ Дагах

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ

2026.05.27

Д/д	Хэлэлцүүлэгт оролцогч	Санал	Хуулийн төсөлд тусгасан байдал
1.	2026 оны 05 сарын 26 МАН-ын дэргэдэх социал демократ ахмадын хорооны 29 дэх удаагийн хуралд 6 дүүргийн /СБД, БЗД, ЧД, ХУД, СХД, Налайх/ 250 гаруй ахмадуудад хуулийн төслийг танилцуулж, санал авсан. Нийт 250 гаруй ахмад оролцсон.		Хуулийн төсөлд тусгасан байдал
2.	Ахмад СХД-н 34-р хороо Дашзэвэг	Хуулийн төслийг дэмжиж байна. Тэтгэврийн зөрүүг арилгахад анхаарч өгнө үү. НДШ-г олон жил ажилласнаар тооцож, тэтгэвэр тогтооход харгалзах ёстой. Манай хороо 1000 гаруй ахмадтай тэдний амьдрал хүнд байна.	Хуулийн төслийг дэмжсэн. Зарчмын өөр саналгүй.
3.	Ахмад СБД 8-р хороо Галидабазар	Илүү ажилласан жилийн нэмэгдлийг 2 хувь болгож өгөх саналтай байна. Тэтгэврийн доод хэмжээг 1,0 сая төгрөг хүргэх.	Хуулийн төслийг дэмжсэн. Зарчмын өөр саналгүй. Тэтгэвэрт гарсны дараа ажилласан жилийн нэмэгдлийг нэмэгдүүлэх нь төсвийн үр дагавар өндөр тул тусгах боломжгүй байна.
4.	Ахмад СБД 8-р хороо	Хувь тэнцүүлсэн тэтгэврийг 1,5 сая төгрөгт хүргэх боломжгүй юу. УИХ-н гишүүддээ уламжилж өгнө үү. Хууль хоорондын зөрчлийг арилгах тасралтгүй 5 жил өндөр цалин төлөөд тэтгэвэрт гарч байгаа шударга бус байдлаа халах, эргэн харгах.	Хуулийн төслийг дэмжсэн. Зарчмын өөр саналгүй.
5.	Ахмад ЧД 16-р хороо Батхуяг	Би улсад 35-н жил ажилласан. 45 хувиар бодогдож байгаа нь шударга бус байна. Цэргийн тэтгэвэр 80 хувиар гарч байна. Энгийн бид 35 жил ажиллаад тэтгэвэрт гарахаар 45 хувиар бодож байгааг эргэн харж, засч залруулах	Хуулийн төслийг дэмжсэн. Зарчмын өөр саналгүй. Цаашид энэхүү саналыг ЗГ-аас өргөн барих НД-ын багц хуульд тусгуулах талаас анхаарч ажиллахаа гишүүн илэрхийлэв.
6.	Ахмад БЗД 45-р хороо Бадамцог	Тэтгэврийн зөрүүг арилгах.	Хуулийн төслийг дэмжсэн. Зарчмын өөр саналгүй.
7.	Ахмад ХУД 17-р хороо Даваасүрэн	Тэтгэврийн зөрүүг арилгах. Сая яригдаж байна 45 хувиар бодож тэтгэвэр тогтоож байгаа асуудлын талаар. Яагаад заавал 45 хувиар тогтоогоод байгаа вэ. Би одоо харуул хамгаалалтын ажил хийж байна. Ахмадуудаас ядаж ХХОАТ-н 10 хувийг суутгадаггүй болмоор байна.	Хуулийн төслийг дэмжсэн. Зарчмын өөр саналгүй. Гишүүн асуулгад хариулт өгч, нийгмийн даатгалын тогтолцоог тайлбарлаж өгөв. Мөн тавьсан санал нь ХХОАТ-ийн хуультай холбоотой байна.
8.	Ахмад БЗД 30-р хороо	Тэтгэврийн зөрүүг арилгах. Доод тэтгэврийг нэмэгдүүлэх	Хуулийн төслийг дэмжсэн. Зарчмын өөр саналгүй.

9.	Ахмад ХУД 17-р хороо Алимаа	Сувилагч хийж байсан. 680к тэтгэвэрт гарсан. Хувь тэнцүүлсэн тэтгэвэрт гарсан ахмадад 36 сарын зээл аваад гар дээрээ 340к амьдарч байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээ авахад үнэхээр хүнд тэтгэвэр хаанаа ч хүрэхгүй байна.	Хуулийн төслийг дэмжсэн. Зарчмын өөр саналгүй.
10.	Ахмад ХУД 24-р хорооны ахмадын дарга	Ахмадын амралт, сувиллын чанарыг сайжруулах, эмчилгээ үйлчилгээг нэмэх. Ахмадуудад зээл олгохгүй байна.	Хуулийн төслийг дэмжсэн. Зарчмын өөр саналгүй.
11.	Ахмад ХУД 4-р хорооны иргэн	УИХ-ын 126 намын квотоо эргэн харах. Махны үнийн талаар гомдол, санал хэлэв.	Хуулийн төслийг дэмжсэн. Зарчмын өөр саналгүй.
12.	Ахмад БЗД 16-р хорооны иргэн Бямбасүрэн	Ахмадын орон сууцны өргөдөл маш их байна. Шийдэх талаас арга хэмжээ авч, өгнө үү. Хуулийн төсөлд энэ талаар тусгах	Хуулийн төслийг дэмжсэн. Зарчмын өөр саналгүй. Ахмадын орон сууцны асуудал хэлэлцүүлж буй НДЭХ-ийн төсөлтэй холбоогүй байна.

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ХУУЛИЙН ТӨСӨЛД ЗАСГИЙН ГАЗРЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

Д/д	Санал, дүгнэлт
1.	
2.	
3.	
4.	
5.	
6.	